



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 10 сарын 12 өдөр

Дугаар А1970

Улаанбаатар хот

Олон улсын кино наадам зохион  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 3/08 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 4.3.8, 2017 оны 02/22 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монголын кино урлагийн хөгжлийг шинэ шатанд хүргэх, кино урлагаар дамжуулан соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор "Улаанбаатар" олон улсын кино наадмыг 2018 оны 10 дугаар сарын 22-28-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Кино наадам зохион байгуулахад шаардагдах, энэ захирамжийн хавсралтаар баталсан 83,256,690 /наян гурван сая хоёр зуун тавин зургаан мянга зургаан зуун ерэн/ төгрөгийг нийслэлийн 2018 оны төсөвт тусгасан "Зүүн хойд Азийн бизнес, аялал жуулчлал, соёл, санхүүгийн төв болох арга хэмжээний зардал"-аас гаргахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс /Э.Ганхүү/-т зөвшөөрсүгэй.

3. Кино наадмыг зохион байгуулах удирдамжийг баталж, өндөр хэмжээнд зохион байгуулахыг нийслэлийн нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан төслүүдийн удирдагч-Нийслэлийн Засаг даргын орлогч Ш.Анхмаад, уг арга хэмжээг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, сурталчлахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс /Э.Дагиймаа/-т тус тус даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН  
ЗАХИРАГЧ

С.БАТБОЛД

111020004319

Нийслэлийн Засаг даргын 2018 оны  
 10 сарын 12-ны өдрийн  
 А.З.О.З.О. захирамжийн хавсралт



“УЛААНБААТАР” ОЛОН УЛСЫН КИНО НААДАМ  
 ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ТӨСӨВ

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ	Хянасан
Уралдааны төсөв						
1	Наадмын уран сайхны удирдагч /олон улсын/	Хүн/сар	1/3	4,500,000	4,500,000	4,500,000
2	Уралдааны шүүгч /Монгол 3, олон улсын 1/	Хүн	4	3,000,000	12,000,000	12,000,000
3	Хангарди цом	Ш	3	1,000,000	3,000,000	3,000,000
4	Үзэгчдийн санал авсан кинонд өгөх цом	Ш	1	500,000	500,000	500,000
5	Уран сайхны киноны шагнал	Ш	1	5,000,000	5,000,000	5,000,000
6	Хүүхэлдэйн киноны шагнал	Ш	1	2,000,000	2,000,000	2,000,000
7	Богино хэмжээний киноны шагнал	Ш	1	1,000,000	1,000,000	1,000,000
ДҮН					28,000,000	28,000,000
Кино толилуулах зардал						
8	Тэнгис Кино театрт заал түрээслэх /монгол кино/	Удаа	3	1,455,300	4,365,900	4,365,900
9	Киноны хадмал гаргах LED дэлгэц түрээслэх	Ш	1	2,200,000	2,200,000	2,200,000
10	Бүтээл гаргах эрхийн төлбөр	Ш	11	476,800	5,244,800	5,244,800
11	Гадаад кино орчуулга	минут	1440	6,000	8,640,000	7,920,000
12	Хадмал бэлтгэх, дүрс тааруулах	Ш	12	757,020	9,084,240	9,084,240
13	Кино хуулах хард драйв	Ш	5	240,000	1,200,000	1,200,000
ДҮН					30,734,940	30,014,940
Засаг даргын нэрэмжит наадмын нээлт, хаалтын шагнал гардуулах ёслол						
14	Тоглолтын танхим, тайз, гэрэл, чимэглэлийн түрээс	Ш	2	5,000,000	10,000,000	10,000,000
15	Лед дэлгэц ба дууны тоног төхөөрөмжийн түрээс	Ш	2	1,250,000	2,500,000	2,500,000
16	Хөтлөгчийн урамшуулал	Хүн	2	1,000,000	2,000,000	2,000,000
17	Морин хуурын чуулга	тоглолт	2	1,500,000	3,000,000	3,000,000
ДҮН					17,500,000	17,500,000
Маркетинг, олон нийттэй харилцах зардал						
18	Наадмын дизайнер	Хүн	1	416,250	416,250	416,250
19	Наадмын ТВ сурталчилгааны эх бэлтгэх зардал /шторк/	Секунд	60	23,000	1,380,000	1,380,000

20	Наадмын плакат А3	Ш	50	1,150	57,500	57,500
21	Наадмын нээлтийн урилга	Ш	1500	400	600,000	600,000
22	Наадмын хаалтын урилга	Ш	1000	400	400,000	400,000
23	Баннер 10м*6м хэвлэлт	м2	60	8,800	528,000	528,000
24	Баннер 10м*6м өлгөлт, буулгалт	м2	60	12,000	720,000	720,000
25	Баннер хөлтэй 80см*180см	Ш	32	20,000	640,000	640,000
26	Тэнгис кино театрын баннер хэвлэлт, өлгөлт, буулгалт, модон карказ, гэрэлтүүлэг	м2	75м2	40,000	3,000,000	3,000,000
ДҮН					7,741,750	7,741,750
НИЙТ ДҮН					83,976,690	83,256,690